

**АЖИЛТНУУДЫН ЗҮРХ СУДАСНЫ ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ,
ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Зорилго:

- ✓ Зүрх судасны үйл ажиллагааг үнэлэх, оношлох, ажилтан бүрийн эрүүл мэндийн одоогийн байдлыг үнэлж тогтоох,
- ✓ Зүрх судасны өвчнийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх..

Хамрах хүрээ /объект/:

- ✓ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ний 113 ажилтан эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах.

Эрүүл мэндийн үзлэг хийлгэх үндэслэл:

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р бүлэгт:
 - “14.1. Ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтныг хамруулна.”
 - “14.2. Энэ хуулийн 14.1-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна” гэж заасан байна.

Баримтлах хууль, эрх зүй:

- ✓ Эрүүл мэндийн тухай хуулийн 44-р зүйл. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх аж ахуйн нэгж байгууллагын үүрэг.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл. Эрүүл мэндийн үзлэг.
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалын 1-р хавсралт. Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам.

Эрүүл мэндийн шинжилгээ, үзлэг хийх ажлыг гүйцэтгэх эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага:

1. Уг ажлыг ЭМЯ-аас эрх авсан хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.
2. Захиалагчийн заасан бүх үзлэг, шинжилгээ (хавсралт-2)-г стандартын дагуу сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмж ашиглан мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.
3. Үзлэгийг гэрээ байгуулснаас хойш хуанлийн 10 хоногийн дотор эхлэх ба компанийн ХАББО-ны газраас гаргасан хуваарийн дагуу үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
4. Үзлэг шинжилгээ хийх эмч, эмнэлгийн ажилтны бүрэн баг бүрэлдэхүүнийг тухайн үзлэг шинжилгээ эхлэхээс өмнө захиалагчид, үзлэгийн боломжит хуваарийн дагуу хүргүүлж батлуулна. Үүний дараа үзлэг шинжилгээг дээрх жагсаалтад орсон эмч, эмнэлгийн ажилтан гүйцэтгэнэ.
5. Үзлэг шинжилгээ хийх эмч, эмнэлгийн ажилтны цагийн хуваарийг урьдчилан зохион байгуулж үндсэн ажилтай нь давхардуулахгүйгээр зохион байгуулна.
6. Үзлэг шинжилгээний дүн мэдээг тохирсон загвар маягтын дагуу файл болон бичгээр хуанлийн 20 хоногийн хугацаанд гаргаж тайлагнах бөгөөд цаашид авах арга хэмжээний заавар зөвлөмжийн хамт компанийн ХАББО-ны газарт хүргүүлнэ. Тайлан авах маягт (хавсралт-3)-ыг хавсаргав.

7. Уг ажлыг хийх эмнэлгийн байгууллага (компани) нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн хавсаргах шаардлагатай:
 - Компанийн дэлгэрэнгүй танилцуулга,
 - Компанийн гэрчилгээний хуулбар,
 - Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар,
8. Эмнэлгийн хэрэгсэл ба эрүүл мэндийн лабораторийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага:
 -
 - Зүрхний цахилгаан бичлэг
 - Зүрхний хэт авиа оношилогоо
 - Цусны дэлгэрэнгүй шинжилгээг иммунологийн аппарат ашиглаж үр дүнг тооцох. /түргэвчилсэн тестр ашиглахгүй байх/
 - Биохимийн шинжилгээ мөн адил аппарат ашиглаж үр дүнг тооцох. /түргэвчилсэн тестр ашиглахгүй байх/

Эдгээр тоног төхөөрөмж нь өөрийн өмчийн байх буюу тухайн эмнэлгийн байранд суурилагдсан байна.

Эрүүл мэндийн үзлэг хийх эмч, эмнэлгийн ажилтанд тавигдах шаардлага:

1. Үзлэг шинжилгээ хийх эмч нар нь мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан байна.
2. Үзлэг шинжилгээг тухайн мэргэжлээр эсхүл тухайн багаж тоног төхөөрөмж дээр ажилласан туршлага дутмаг, дадлагажигч эмч, эмнэлгийн ажилтнаар хийлгэхгүй.
3. Ажилтнуудад Монгол улсын оношлогоо, эмчилгээний стандартын дагуу чанартай сайн үзлэг, шинжилгээ хийж зөвлөгөө өгнө.
4. Ажилтнуудад үзлэг шинжилгээ хийх эмч эмнэлгийн ажилтан нь тухайн үзлэг шинжилгээнд зориулан хангалттай цаг гаргаж зөвхөн манай ажилтанд үзлэг хийх шаардлагатай бөгөөд давхар гадны хүн үзэх, өөр тасагт хамт хариуцлага хүлээн ажиллахыг зөвшөөрөхгүй.
5. Үзлэг шинжилгээ хийх эмч, эмнэлгийн ажилтны мэдээлэлд дараах бичиг баримтыг хавсаргасан байх шаардлагатай:
 - Мэргэжлийн лиценз,
 - Төрөлжсөн нарийн мэргэжлийн гэрчилгээ,
 - Мэргэжил дээшлүүлсэн байдал, ажлын туршлага зэргийг тодорхойлох бусад бичиг баримтууд.

Гарах үр дүн:

- ✓ Ажилтнуудын эрүүл мэндийн байдлыг үнэлж, дүгнэлт гаргана.
- ✓ Ажилтнуудын өвчлөлийн байдлыг тандаж, судалгаа хийх, эрүүлжүүлэх, эмчлүүлэх төлөвлөгөө гаргах үндсэн баримт болно.
- ✓ Ажилтны эрүүл мэндийн байдлыг дэмжинэ.

Хавсралт №2

НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

Үзлэг шинжилгээг хийх эмнэлгийн байгууллага болон эмч, эмнэлгийн ажилтан нь үйл ажиллагаандаа дараах стандартыг баримтална:

- ✓ "Эмчилгээний оношлогооны түгээмэл үйлдлийн стандарт MNS4621:2008,

- | | | |
|-----|----------------|------------|
| 1.1 | мэргэжлийн эмч | Зүрх судас |
|-----|----------------|------------|

ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ:

Техникийн тодорхойлолт:

1.1	Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг	Зүрх судас
	Багажийн шинжилгээ	Даралт пульс үзэх
		Зүрхний цахилгаан бичлэг
		Зүрхний хэт авиа оношилогоо
		Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
	Биохимийн шинжилгээ	Холестерин, Триглицерид, LDL, HDL Глюкозжсон гемоглобин Чихрийн шижин илрүүлэх (өлөн үеийн сахар)

ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦАХИМ ТАЙЛАНГИЙН МАЯГТ:

№	Овог нэр	Нас	Хүйс	ОАК	Биохими					
					LDL	HDL	Холесте	Триглице	Глюкозж сон	гемоглоб ин
1										
2										
3										

ҮЗЛЭГИЙН ХАРИУГ НЭГТГЭХ МАЯГТ:

1.2 Маягтыг Microsoft EXCEL программ дээр доорх загварын дагуу нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийн оношийг дэлгэрэнгүй бичиж, нэгтгэж өгнө.

№	Овог нэр	Нас	Хүйс	Зүрх судас										
1														
2														
3														

Багажийн шинжилгээний хариуг нэгтгэх маягт:

1.3 Маягтыг Microsoft EXCEL программ дээр доорх загварын дагуу шинжилгээнд гарсан өөрчлөлтүүдийг дэлгэрэнгүй бичиж, нэгтгэж өгнө.

№	Овог нэр	Нас	Хүйс	ЭКГ	Зүрхний хэт авиа
1					

Зорилго: Зүрх судасны үйл ажиллагааг үнэлэх, оношлох

Ач холбогдол: Зүрх судасны өвчнийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх.

№	Шинжилгээний төрөл	Талбайр	
1	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ	ЦДШ хийснээр бид таны цусанд цус багадалт, цусны өтгөрөлт, үрэвсэл болон цусны зарим өвчлөл болон хавдарыг оношлох боломжтой.	
2	Зүрхний цахилгаан бичлэг	Зүрхний цахилгаан дамжуулах чанар дээр үндэслэн зүрхний эмгэгийг оншлоход чиглэсэн анхан шатны арга юм.	
3	Зүрхний ЭХО шинжилгээ	Зүрхний бичлэг, эмчийн үзлэг чагналтаар оношлогдохгүй эмгэгийг илрүүлдэгээрээ онцлогтой төдийгүй үйлчлүүлэгчдэд ямар нэг хортой нөлөөгүй чухал шинжилгээний төрөл юм. Зүрхийг олон талаас нь дүрсжүүлэн харж, зүрхэн дахь бүтцийн болон үйл ажиллагааны, цаашлаад цусан хангамжийн байдлыг нягтлан оношилдог.	
4	Биохимийн шинжилгээ	Их нягтрал липопротейн /ИНЛП/ LDL	Сайн холестерол нь захын судасны эд эсээс элэг рүү триглицерид зөөвөрлөх буюу судас хатуурлын эсрэг үйлдэлтэй.
		Бага нягтрал липопротейн /БНЛП/ HDL	Муу холестерол нь триглицеридийг булчингийн эд эсэд зөөвөрлөх үүрэг гүйцэтгэдэг. Муу холестерол болох БНЛП нь артерийн судасны доторх давхаргад хуримтлагдсан судас хатуурлыг бий болгодог. Судас хатуурал үүссэнээр судасны доторх хөндий багасч эд эрхтэнд очиж цусан хангамжийн хязгаарладаг. Тухайбал, зүрхийг тэжээх титэм судас хатуурахад ишеми өвчин үүсэнээр зүрхний цочмог шигдээс үүсэх эрсдэлтэй.
		Нийт Холестерол	Сайн ба муу холестеролын нийлбэр юм. Энэ нийт холестеролын ихэнх хэсгийг БНЛЛ буюу муу холестерол бүрдүүлдэг учраас цусанд агуулагдах нийт холестеролын түвшин ихсэхэд зүрх судасны эмгэгээр өвдөх эрсдэл нэмэгдэнэ.
		Триглицерид	Триглицерид бол нарийн гэдсэнд липаза ферментээр задарсан өөх тосны гол бүрэлдэхүүн хэсэг, булчингийн эд эс нь тос болох Триглицеридыг ашиглан их хэмжээний энерги үүсдэг. Энэ энергийн тусламжтайгаар булчин агшиж хүни бие хөдлөх боломжийг олгоно.
	Глюкозжсон гемоглобин	Чихрийн шижин өвчнийг оношлох зорилгоор хийгддэг.	